



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/156/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2108

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:\2022 он пармаа\гэрчилгээ\A4-toot.docx

0050:0192

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,230,141.50	8,674,490.50
33	АВЛАГА	4,151.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	4,151.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,225,990.50	8,674,490.50
354	Хангамжийн материал	8,225,990.50	8,674,490.50
35410	Бичиг хэргийн материал	1,030,800.00	751,800.00
35420	Аж ахуйн материал	4,743,200.00	5,470,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	760,000.00	420,000.00
35450	Барилгын засварын материал	225,000.00	225,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,466,990.50	1,806,990.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,022,009,772.56	2,166,296,983.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,022,009,772.56	2,166,296,983.50
392	Биет хөрөнгө	1,962,009,772.56	2,106,296,983.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,868,941,351.00	2,031,104,487.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,298,045.12	-93,447,067.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,400,000.00	21,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,336,666.38	-17,476,666.34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,920,992.00	49,420,992.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,660,612.89	-34,337,150.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,271,445.00	41,369,345.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,177,198.06	-31,572,988.21
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	6,500,000.00	6,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,617,158.00	4,701,158.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-874,499.94	-1,457,499.90
39217	Ном	122,705,848.95	130,092,373.95
393	Биет бус хөрөнгө	60,000,000.00	60,000,000.00
39301	Програм хангамж	4,835,200.00	4,835,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,835,200.00	-4,835,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	60,000,000.00	60,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,030,239,914.06	2,174,971,474.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,897,359.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,897,359.18
413	Өглөг	00.00	3,897,359.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	3,176,213.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	721,146.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,030,239,914.06	2,171,074,114.82
51	Засгийн газрын хувь оролцоо	2,030,239,914.06	2,171,074,114.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,189,286,285.85	1,189,286,285.85
51101	Өмч: - төрийн	1,189,286,285.85	1,189,286,285.85
512	Хуримтлагдсан үр дүн	-179,232,106.92	-38,397,906.16
51210	Өмнөх үеийн үр дүн	-179,232,106.92	-179,232,106.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	140,834,200.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,020,185,735.13	1,020,185,735.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,030,239,914.06	2,174,971,474.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	183,523,830.50	344,996,328.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,362,730.50	166,902,728.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,362,730.50	166,902,728.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,362,730.50	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,362,730.50	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	174,161,100.00	178,093,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	174,161,100.00	176,843,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	174,161,100.00	176,843,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	203,664,425.43	204,162,127.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,664,425.43	204,162,127.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,577,189.43	203,565,027.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106,968,300.00	109,538,112.18
210101	Үндсэн цалин	106,968,300.00	109,538,112.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,037,349.00	14,045,651.00
210201	Тэтгэврийн даатгал	9,876,949.00	9,885,251.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,040,100.00	1,040,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	832,100.00	832,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	208,000.00	208,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,080,200.00	2,080,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,080,706.00	31,486,546.00
210301	Гэрэл, цахилгаан	1,814,295.00	1,594,986.00
210302	Түлш, халаалт	27,858,105.00	27,486,664.00
210303	Цэвэр, бохир ус	2,408,306.00	2,404,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,022,188.00	5,710,978.00
210401	Бичиг хэрэг	1,449,300.00	876,300.00
210402	Тээвэр, шатахуун	796,300.00	373,100.00
210403	Цуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,339,511.00	1,118,198.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,437,077.00	1,375,680.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,367,700.00
2105	Нормативт зардал	332,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,000,000.00
2107	Томилот, зочны зардал	520,000.00	216,000.00
210702	Дотоод албан томилот	520,000.00	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	858,370.00	414,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	444,370.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	285,700.00	285,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,300.00	95,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,757,476.43	41,153,740.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,118,200.00	2,209,390.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,639,276.43	38,944,350.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,087,236.00	597,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,587,236.00	97,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,587,236.00	97,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-20,140,594.93	140,834,200.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-20,140,594.93	140,834,200.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	174,161,100.00	178,093,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	174,161,100.00	178,093,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	174,161,100.00	176,843,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	174,161,100.00	176,843,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	165,653,100.00	161,524,567.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	165,653,100.00	161,524,567.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,565,864.00	160,927,467.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106,968,300.00	106,361,899.00
210101	Үндсэн цалин	106,968,300.00	106,361,899.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,041,500.00	14,041,500.00
210201	Тэтгэврийн даатгал	9,881,100.00	9,881,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,040,100.00	1,040,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	832,100.00	832,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	208,000.00	208,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,080,200.00	2,080,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,080,706.00	30,765,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,814,295.00	1,594,986.00
210302	Түлш, халаалт	27,858,105.00	26,765,518.00
210303	Цэвэр, бохир ус	2,408,306.00	2,404,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,744,311.00	4,343,278.00
210401	Бичиг хэрэг	1,486,300.00	876,300.00
210402	Тээвэр, шатахуун	796,300.00	373,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,339,511.00	1,118,198.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,122,200.00	1,375,680.00
2105	Нормативт зардал	332,800.00	1,386,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,800.00	1,386,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000.00	1,190,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	190,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,000,000.00

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	520,000.00	216,000.00
210702	Дотоод албан томилолт	520,000.00	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	858,370.00	414,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	444,370.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	285,700.00	285,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,300.00	95,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,999,877.00	2,209,390.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,999,877.00	2,209,390.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,087,236.00	597,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,587,236.00	97,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,587,236.00	97,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,508,000.00	16,569,033.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,508,000.00	16,569,033.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,508,000.00	16,569,033.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,508,000.00	16,569,033.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,508,000.00	16,569,033.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,508,000.00	-16,569,033.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,189,286,285.85	41,492,439.50	-56,762,199.83	1,174,016,525.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,189,286,285.85	41,492,439.50	-56,762,199.83	1,174,016,525.52
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,886,593.70	-18,886,593.70
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,189,286,285.85	1,020,185,735.13	-179,232,106.92	2,030,239,914.06
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,189,286,285.85	1,020,185,735.13	-179,232,106.92	2,030,239,914.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,189,286,285.85	1,020,185,735.13	-179,232,106.92	2,030,239,914.06
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	140,834,200.76	140,834,200.76
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,189,286,285.85	1,020,185,735.13	-38,397,906.16	2,171,074,114.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	176,843,600.00	176,746,500.00	97,100.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	176,843,600.00	176,746,500.00	97,100.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	176,843,600.00	176,246,500.00	597,100.00	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106,361,900.00	106,361,899.00	1.00	100.0
210101	Үндсэн цалин	106,361,900.00	106,361,899.00	1.00	100.0

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд тө	14,041,500.00	14,041,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	9,881,100.00	9,881,100.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,040,100.00	1,040,100.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	832,100.00	832,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	208,000.00	208,000.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,080,200.00	2,080,200.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	30,765,400.00	30,765,400.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,664,400.00	1,594,986.00	69,414.00	95.8
210302	Түлш, халаалт	26,695,600.00	26,765,518.00	-69,918.00	100.3
210303	Цэвэр, бохир ус	2,405,400.00	2,404,896.00	504.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	8,762,600.00	8,740,211.00	22,389.00	99.7
210401	Бичиг хэрэг	876,300.00	876,300.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	373,100.00	373,100.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,141,100.00	1,118,198.00	22,902.00	98.0
210404	Ном, хэвлэл	4,397,000.00	4,396,933.00	67.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч	599,400.00	600,000.00	-600.00	100.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	1,375,700.00	1,375,680.00	20.00	100.0
2105	Нормативт зардал	1,386,000.00	1,386,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386,000.00	1,386,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,787,900.00	11,787,900.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,597,900.00	10,597,900.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	190,000.00	190,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	216,000.00	216,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	216,000.00	216,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	488,700.00	414,000.00	74,700.00	84.7
210803	Даатгалын үйлчилгээ	285,700.00	285,700.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,000.00	95,300.00	74,700.00	56.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,533,600.00	2,533,590.00	10.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,533,600.00	2,533,590.00	10.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамш	500,000.00	500,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	176,843,600.00	176,746,500.00	97,100.00	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,843,600.00	176,746,500.00	97,100.00	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	176,843,600.00	176,746,500.00	97,100.00	99.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	11.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг дарга Б.Түвшинчимэг, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баатархуяг нар зурсан байна

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын үйлчилгээ, номын сангийн үйлчилгээг ард иргэдэд хүргэж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 203,664.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.054.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,138.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 2,143.7 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Нийтийн номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,731.6 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө болон өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,230.1	8,674.5	444.3
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4.2	-	(4.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	8,226.0	8,674.5	448.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,022,009.8	2,166,297.0	144,287.2
Үндсэн хөрөнгө	2,166,192.0	2,349,423.6	183,231.6
Хуримтлагдсан элэгдэл	(144,182.2)	(183,126.6)	(38,944.4)
Нийт хөрөнгө	2,030,239.9	2,174,971.5	144,731.6
Өр төлбөр	-	3,897.4	3,897.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,030,239.9	2,171,074.1	140,834.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,030,239.9	2,174,971.5	144,731.6

Бараа материалын дансны үлдэгдэл 8,674.5 мянган төгрөг болж 448.5 мянган төгрөгөөр өссөн нь, аж ахуйн материал 727.5 мянга, бусад хангамжийн материал 340.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба урсгал төсвийн худалдан авалтаар аж ахуйн материал дээр 3,036.7 мянган төгрөгийн эд материал худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,349,423.6 мянган төгрөг болж 183,231.6 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021.06.10-ны өдрийн А/129 дугаар албан бичгээр 162,163.1 мянган төгрөгийн номын сангийн дээврийн засварын ажлыг барилгын сайжруулалтаар бүртгэсэн, урсгал төсвийн худалдан авалтаар 12,172.1 мянган төгрөгийн хөрөнгө, бусад байгууллагаас 1,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,171,074.1 мянган төгрөг болж 140,834.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 140,834.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 249,545.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 249,545.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74,345.1 мянган төгрөгөөр бууруулж 175,200.8 мянган төгрөгөөр анх баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 176,843.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 176,843.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 176,746.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 97.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 176,746.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 74.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 22.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2021 онд 597 шинэ уншигчдад 4903 ном олгон үйлчилсэн бөгөөд шинээр 309 нэр төрлийн 458 ширхэг номоор сан хөмрөгөө баяжуулж, урагдаж гэмтсэн 249 номыг сэргээн засварлаж, нийт 15 төрлийн соёл, олон нийтийн ажлыг зохион байгуулсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бөгөөд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 15 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 96 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 204,162.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 497.7 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 200,109.1 мянган төгрөгийн 21 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 175,200.8 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 1642.8 мянган төгрөг хасаж баталснаас орон нутгийн төсвөөс 176,843.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 34,671.8 мянган төгрөгөөр, тодотголоор 30,765.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 30,765.4 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 3,906.4 мянган төгрөг буюу 12.7 хувь хэмнэсэн нь тогтоолын 1.8 дахь заалттай нийцээгүй.

- Бичиг хэргийн зардлыг 876.3 мянган төгрөгөөр баталж зарцуулсан дээрх тогтоолын 1.9 дэх заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 946.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 946.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлж, нотлох баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.07.01-ны өдрийн №38 тоот албан бичгээр хүргүүлж, ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,009.1 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 240.2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,428.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,188.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Монголын цахилгаан холбоо ХХК -иас авсан 90.2 мянган төгрөгийн өртөг бүхий VDSL модем, 150.0 мянган төгрөгийн өртөг бүхий STP кабелин утас зэрэг бараа материалын шинж чанартай хөрөнгүүдийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “ Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.30 “ Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх үндсэн хөрөнгөд бүртгэсэн хөрөнгийг санхүүгийн тайланд бараа материалд бүртгэж, залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Тайлант хугацааны зардлыг анхан шатны баримттай тулгахад 1,386.0 мянган төгрөгөөр ажилчдад дүрэмт хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудаар 1,386.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад Б.Түвшинчимэгт 12 дугаар сард үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 40 хувиар тооцон олгосон 373,047 төгрөгийн даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл болох 42,900.0 /Дөчин хоёр мянга есөн зуун/ төгрөгийг суутган тооцоогүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 42,900.0 төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

1. Нярав нь тайлан гаргахдаа эхний болон эцсийн үлдэгдлийг нэр төрлөөр нь салгаагүй бөөн дүнгээр тайлагнаж, нягтлан бодогч санхүүгийн программд нэр төрлөөр хүлээн авч оруулж байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Маягт, заавар батлах тухай" журмын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 9 "д заасан "Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна" заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" журмыг бүрэн хэрэгжүүлж, нярав тайланг бүрэн гаргаж ажиллах.

2. Бараа үйлчилгээний бусад зардлаас 63.2 мянган төгрөгийг шуудан үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулсан, бараа материалын үнийг шилжүүлэхдээ и-баримтгүй 88.0 төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" заалтуудыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид дээрх хууль, журмуудыг мөрдлөг болгон ажиллах зөвлөмжийг хүргүүлэв..

3. Тайлант оны эцэст Нийгмийн даатгалын хэлтэст шимтгэлийн 3188.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь Соёлын яамнаас баталсан орон тооноос нэг ажилтан илүү ажиллуулсантай холбоотой бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид батлагдсан орон тоог мөрдөн ажиллаж, төсөвт ер, авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

4. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулган шалгахад анх батлагдсан төсвөөс 0.9 хувиар өсгөж 176,843.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг анх баталснаас 12.7 хувиар хэмнэсэн ч, бичиг хэргийн зардалд хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.9 “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, бичиг хэрэг болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Нийтийн номын сан	7	5,009.1	1	240.2	2	1,428.9	0	0	4	3,340.0

_____оОо_____